



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар E/16

Төрийн ордон, Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮН Д.СОЛОНГО ТАНАА

Байр суурь илэрхийлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан иргэдийн мэдээлэлтэй холбогдуулан ирүүлсэн Таны 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2/59 дугаар “байр суурь тодруулах” тухай албан бичиг, түүнд хавсаргасан баримт, мэдээлэлтэй танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн батлагдах нөхцөлийг бүрдүүлсэн, Монгол Улсын Ерөнхий сайд, сайдууд, Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлгийн дарга болон Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн зөвшилцлийн Ажлын хэсгийг даргалж, Үндсэн хуульд гарын үсгээ зурж, ёсчлон баталгаажуулсан хүний хувьд тодорхой хэдэн зүйлийг Танд уламжилъя.

1. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хуулийн ...өмнө эрх тэгш байна. Хүнийг ...эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан бол Арван зургадугаар зүйлд “сонгох, сонгогдох” эрх нь иргэний үндсэн эрх, эрх чөлөө мөн бөгөөд Монгол Улсын иргэн энэ эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж хуульчилсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хууль “Монголын ард түмэн бид” хэмээн эхэлж, “Мэдэгтүн, Сахигтун” гэж төгсдөг. Үндсэн хууль бол аль нэг нам, салбар, хэсэг бүлэгт зориулагдсан, дуртайгаараа тайлбарлаж, дур зоргоороо хэрэгжүүлдэг ердийн дүрэм, журам биш гэдгийг Та сайн мэднэ.

2. Үндсэн хуулийн Жаран дөрөв болон Жаран зургадугаар зүйлд тус тус зааснаар Үндсэн хуулийн цэц нь гагцхүү Улсын Их Хурлын баталсан хуулийн үг, өгүүлбэр Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах эрхтэй. Харин батлагдсан хуульд ямар үг, өгүүлбэр байх ёстойг тогтоох, мөн хянах, ийм үг, өгүүлбэртэй хууль гарга хэмээн Улсын Их Хуралд даалгах эрх Үндсэн хуулийн цэцэд байхгүй юм.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, иргэн О.Мөнхсайхан зэрэг нэр бүхий иргэд Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 24 үгтэй, 2 таслалтай, 1

0000000118

өгүүлбэрээс "...зөвхөн нэг удаа..." гэх 3 үгийг таслан авч, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд "Х.Баттулга нэр дэвшиж болохгүй, Х.Баттулгыг нэр дэвшүүлж огт болохгүй" гэдэг шаардлагыг тусгаагүй нь Үндсэн хуулийг зөрчсөн байна гэх агуулга бүхий мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд гаргаж, Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь "өр зээлгүй, татвараа цаг хугацаанд нь төлдөг, сэтгэцийн эмгэггүй байх ёстой" гэсэн зүй ёсны шаардлага тогтоосон хуулийн заалтуудыг хүчингүй болгохыг хүссэн байна.

Өөрт таалагддаггүй хүний эрхийг боомилох, иргэдийн сонгох эрхийг хясах явцуу зорилгоор, хуульт ёс, эрх зүйн онол, практикт огт нийцэхгүй байдлаар Үндсэн хуулийг тайлбарлан хэрэгжүүлэхийг шаардах, нэг нам, бүлэглэл болон нэг хэсэг хүний тааллаар хууль үйлчлүүлэхийг тулгах нь өөгшүүлэн дэмжих явдал мөн үү.

Монгол Улсын Ерөнхийлөгчид "өр зээл, татвараа төлдөггүй этгээд, сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй хүн" хэн боловч нэр дэвшиж болно "гагцхүү Х.Баттулга л нэр дэвшиж болохгүй" гэсэн хуулийг нэхэн шаардаж буй иргэдийн мэдээллээр Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулиа илэрхий зөрчсөн байдлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа хүртэл үүсгэж байгаа нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоох Монголын ард түмний эрхэм зорилго, Үндсэн хуулийн суурь зарчмуудад нийцэх үү.

3. Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсон онцгой байгууллага. Тиймээс Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдаж, аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бусаар ажиллах шаардлагатай.

Таны хянаж буй асуудлыг Үндсэн хуулийн цэц 1997 онд эцэслэн шийдвэрлэж, хууль зүйн хувьд ямар ч эргэлзээгүй бөгөөд маргаангүй жишиг тогтоосон байна.

1992 оноос 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл мөрдөгдөж ирсэн Үндсэн хууль Монгол Улсын Ерөнхийлөгчид нэг хүн 2 удаа нэр дэвшихийг зөвшөөрч байсан бөгөөд 1990 онд Монгол Улсын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан П.Очирбат гуай 1993 онд шинэ Үндсэн хуулийн дагуу нэр дэвшин сонгогдож, 1997 онд дахин нэр дэвшихэд 3 дахь удаагаа нэр дэвшлээ гэдэг маргаан үүсэж, уг маргааныг Үндсэн хуулийн цэц 1997 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтээрээ Үндсэн хууль зөрчөөгүй хэмээн шийдвэрлэж, П.Очирбат гуайг дахин нэр дэвших эрхтэйг тогтоожээ.

Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлт өнөөдөр ч хүчин төгөлдөр байна.

4. Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно" гэж заасан бол "төрийг удирдах хэрэгт оролцох болон сонгох" эрх нь ард иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө мөн гэдгийг Үндсэн хуульд маш тодорхой зааж баталгаажуулсан байдаг.

Монголын ард түмнээс энэхүү эрх мэдэл, эрх, эрх чөлөөг нь хэн ч, ямар ч аргаар хураан авч болохгүй. Тиймээс би Монгол түмнийг дарлаж, Монгол Улсын баялгийг

сорон мөлжиж ирсэн тодорхой бүлэглэл, хэсэг хүмүүсийн хүслийг биелүүлж, өөгшүүлэхтэй эвлэрч огт болохгүй гэсэн хатуу байр суурьтай байна.


Би өнгөрсөн 30 жилийн алдаа завхралыг засах, нийт ард түмний өмч болсон байгалийн баялгийг хэдхэн гэр бүл эзэмшдэг, үр өгөөжийг нь хүртдэг байдлыг халах, энэ зүй бус орлогоороо төрийн эрхийг худалдан авдаг, эд хөрөнгө, эрх мэдлийнхээ сүр нөлөөгөөр хууль шүүхийн байгууллагуудыг эрхшээж хонгил байгуулдаг, өөрсдийнх нь эрх ашгийг хөндсөн, Монголын ард түмний эрхийг хамгаалсан хэнийг ч дарлаж, дардаг гажууд ноёрхлыг таслан зогсоох үндсэн зорилгын хүрээнд “иргэд нь улс орныхоо эзэн байдаг, баялгийнхаа үр өгөөжийг шууд хүртдэг, хууль шүүхийн өмнө эрх тэгш амьдардаг шударга тогтолцоог бүрдүүлэх гэж” Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжин батлалцсан юм.

Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлт Монголын төрд эрмэлзэн зорих, эрхэмлэн хэрэгжүүлэх тов тодорхой бодлогыг бий болгосон. Байгалийн баялгийн үр өгөөж жинхэнэ эзэддээ хүрэх, Монголын ард түмний амьдрал, хөгжилд бодитойгоор нэмэр болохын эхлэл тавигдаж, нэн тодорхой ажлууд хийгдээд байна.

Таван толгойн ордын үр өгөөжөөр ашигт малтмалын 170 гаруй ордын үнэ цэнийг өсгөх, хоёрдогч, гуравдагч зах зээлд хүрэх онцгой ач холбогдол бүхий төмөр замаа барьж, байгуулж байна. Салхитын ордоо эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ахмадуудынхаа өр зээлийг тэглэж, нийт ахмадууддаа мөнгөн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүллээ. Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралыг даван туулахад Хармагтайн ордыг ашиглана гэдгээ Засгийн газар ил тод зарлаж байна.

Дөнгөж эхэлж буй энэ бодлого, өөрчлөлт нь ард түмний баялагт эзэн сууж, үр өгөөжийг нь сорон мөлжиж ирсэн хэдэн гэр бүл, тодорхой бүлэглэлийн этгээдүүдэд огт таалагдахгүй байгаагаас тэд “ард түмэнд ашигтай, улс оронд хэрэгтэй Монгол төрийн бодлогыг таслан зогсоох, өөрсдийнх нь зүй бус ашиг сонирхлыг хөндөж саад учруулсан, эх орныхоо зүй ёсны эрх ашгийг тэргүүнд тавьж хамгаалсан хүмүүсийг замаасаа зайлуулах” увайгүй оролдлого, хуйвалдааныг хүчтэй явуулж байгаа нь Үндсэн хуулийн цэцээс нэгэнт жишиг тогтоож, маргаангүй болгосон асуудлыг маргаан болгож буй энэхүү үйл ажиллагаагаар тод илэрч буйг цохон тэмдэглэе.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА